



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Есөнбулаг сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ГАА-2022/108/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор Р.Цанжидмаа Утас: 99029885 Цахим хаяг: tsania.0215@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
3. Аудитын тайлан .....	8
3.1 Ерөнхий зүйл .....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4 Материаллаг байдал.....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	10
3.8 Аудитын гол асуудал.....	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт.....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	13

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ЕСӨНБУЛАГ СУМЫН 3 ДУГААР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Ж.НЭРГҮЙ ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25 № 77

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Есөнбулаг сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Есөнбулаг сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Үр дүнгийн урамшуулал илүү олгосон, хоолны зардлын норматив хэтрүүлсэн, төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлаагүйгээр тавилга эд хогшил худалдан авсан, батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй зэрэг 10.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь: Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоол, Засгийн азрын 2019 оны 450 дугаар тогтоол, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" журам, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

07020377

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1.00</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>60,435,541.00</b>	<b>75,267,186.00</b>
<b>35.00</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	60,435,541.00	75,267,186.00
<b>354.00</b>	<b>Хангамжийн материал</b>	60,435,541.00	75,267,186.00
35,410.00	Бичиг хэргийн материал	381,566.00	515,066.00
35,420.00	Аж ахуйн материал	5,717,559.00	7,252,014.00
35,440.00	Түлш, шатах тослох материал	240,000.00	240,000.00
35,460.00	Хүнсний материал	2,893,870.00	3,375,060.00
35,470.00	Бусад хангамжийн материал	51,202,546.00	63,885,046.00
<b>2.00</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>370,326,094.11</b>	<b>616,442,606.50</b>
<b>39.00</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	370,326,094.11	616,442,606.50
<b>392.00</b>	<b>Биет хөрөнгө</b>	296,138,594.11	539,918,856.50
39,201.00	Барилга, байгууламж, орон сууц	271,936,067.75	515,684,567.75
39,202.00	Хуримтлагдсан элэгдэл	(41,388,974.16)	(63,542,178.07)
39,205.00	Машин тоног төхөөрөмж (компьютер)	53,893,399.00	52,383,324.00
39,206.00	Хуримтлагдсан элэгдэл	(19,577,977.31)	(11,509,341.51)
39,207.00	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,005,462.49	48,658,199.43
39,208.00	Хуримтлагдсан элэгдэл	(17,358,956.06)	(8,163,579.30)
39,214.00	Бусад үндсэн хөрөнгө	18,608,125.00	14,267,075.00
39,215.00	Хуримтлагдсан элэгдэл	(6,978,552.60)	(7,859,210.80)
<b>393.00</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	74,187,500.00	76,523,750.00
39,301.00	Програм хангамж	2,711,250.00	2,711,250.00
39,302.00	Хуримтлагдсан элэгдэл	(2,523,750.00)	(187,500.00)
39,303.00	Бусад биет бус хөрөнгө	74,000,000.00	74,000,000.00
<b>3.00</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>430,761,635.11</b>	<b>691,709,792.50</b>
<b>5.00</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>430,761,635.11</b>	<b>691,709,792.50</b>
<b>51.00</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	430,761,635.11	691,709,792.50
511.00	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	265,974,028.00	265,974,028.00
51,101.00	Өмч: - төрийн	265,974,028.00	265,974,028.00
<b>512.00</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(122,926,832.06)	138,021,325.33
51,210.00	Өмнөх үеийн үр дүн	(122,926,832.06)	(122,926,832.06)
51,220.00	Тайлант үеийн үр дүн	-	260,948,157.39
51,300.00	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	287,714,439.17	287,714,439.17
<b>6.00</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>430,761,635.11</b>	<b>691,709,792.50</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	492,573,684.43	719,289,765.43
12.00	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	34,399,518.43	272,721,365.43
120.00	Нийтлэг татварын бус орлого	34,399,518.43	272,721,365.43
120,004.00	Төсөв байгууллагын өөрийн орлого	34,399,518.43	272,721,365.43
1,200,045.00	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	34,399,518.43	272,721,365.43
120,017.00	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө		271,072,948.43
120,018.00	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал		1,648,417.00
13.00	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	458,174,166.00	446,568,400.00
1,310.00	Улсын төвлөрсөн төсвөөс	389,133,330.00	391,444,700.00
131,007.00	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	389,133,330.00	391,444,700.00
1,320.00	Орон нутгийн төсвөөс санхүүжих	60,853,800.00	55,123,700.00
132,001.00	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,853,800.00	55,123,700.00
2.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	474,341,871.74	458,341,608.04
21.00	УРСГАЛ ЗАРДАЛ	474,341,871.74	458,341,608.04
210.00	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	454,399,346.41	452,760,812.58
2,101.00	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	288,345,317.00	287,918,536.34
210,101.00	Үндсэн цалин	264,261,285.00	263,108,202.67
210,104.00	Урамшуулал	24,084,032.00	24,810,333.67
2,102.00	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,355,512.67	37,666,180.72
210,201.00	Тэтгэврийн даатгал	27,807,522.60	26,414,415.33
210,202.00	Тэтгэмжийн даатгал	-	2,858,251.66
210,203.00	ҮОМШӨ-ний даатгал	2,286,710.03	2,303,941.55
210,204.00	Ажилгүйдлийн даатгал	407,350.45	532,624.01
210,205.00	Эрүүл мэндийн даатгал	5,853,929.59	5,556,948.17
2,103.00	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,923,581.00	53,027,506.98
210,301.00	Гэрэл, цахилгаан	2,501,099.00	2,428,217.88
210,302.00	Түлш, халаалт	43,973,906.00	46,628,061.10
210,303.00	Цэвэр, бохир ус	4,448,576.00	3,971,228.00
2,104.00	Хангамж, бараа материалын зардал	9,104,808.00	5,102,492.50
210,401.00	Бичиг хэрэг	600,400.00	1,109,800.00
210,402.00	Тээвэр, шатахуун	238,900.00	240,000.00
210,403.00	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	845,460.00	913,230.50
210,405.00	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	236,000.00	96,000.00
210,406.00	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,965,690.00	2,743,462.00
210,408.00	Бараа материал актисны зардал	5,218,358.00	
2,105.00	Нормативт зардал	21,560,700.00	16,061,010.00
210,501.00	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	345,000.00	550,000.00
210,502.00	Хоол, хүнс	21,215,700.00	15,511,010.00
2,106.00	Эд хогшил, урсгал засварын зардал	5,028,500.00	1,476,000.00
210,603.00	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,109,500.00	520,000.00
210,604.00	Урсгал засвар	3,919,000.00	956,000.00
2,108.00	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	544,000.00	1,266,000.00
210,801.00	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	618,000.00
210,802.00	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
210,806.00	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	
2,109.00	Бараа үйлчилгээний бусад зардал	42,536,927.74	50,243,086.04
210,902.00	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	436,500.00	293,000.00
210,903.00	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	42,100,427.74	49,950,086.04
213.00	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,942,525.33	5,580,795.46
2,132.00	Бусад урсгал шилжүүлэг	10,090,374.00	1,920,000.00
213,208.00	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,187,036.00	
213,209.00	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,903,338.00	1,920,000.00
2,134.00	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,930,219.00	96,193.02
213,403.00	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,930,219.00	96,193.02
2,135.00	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,921,932.33	3,564,602.44
213,503.00	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,921,932.33	3,564,602.44
3.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	18,231,812.69	260,948,157.39
5.00	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	18,231,812.69	260,948,157.39

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капита	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	265,974,028.00	287,714,439.17	-122,926,832.06	0.00	430,761,635.11
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	265,974,028.00	287,714,439.17	-122,926,832.06	0.00	430,761,635.11
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	265,974,028.00	287,714,439.17	-122,926,832.06	0.00	430,761,635.11
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	265,974,028.00	287,714,439.17	-122,926,832.06	0.00	430,761,635.11
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	265,974,028.00	287,714,439.17	-122,926,832.06	0.00	430,761,635.11
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	260,948,157.39	0.00	260,948,157.39
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	265,974,028.00	287,714,439.17	138,021,325.33	0.00	691,709,792.50

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	458,174,166.00	446,568,400.00
13.00	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	458,174,166.00	446,568,400.00
1,310.00	Улсын төвлөрсөн төсвөөс	389,133,330.00	391,444,700.00
131,007.00	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	389,133,330.00	391,444,700.00
1,311.00	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,187,036.00	-
131,104.00	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,187,036.00	
1,320.00	Орон нутгийн төсвөөс санхүүжих	60,853,800.00	55,123,700.00
132,001.00	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,853,800.00	55,123,700.00
2.00	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	437,677,166.00	421,574,750.00
21.00	УРСГАЛ ЗАРДАЛ	437,677,166.00	415,993,954.54
210.00	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	417,734,640.67	415,993,954.54
2,101.00	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	288,345,317.00	287,918,536.34
210,101.00	Үндсэн цалин	264,261,285.00	263,108,202.67
210,104.00	Урамшуулал	24,084,032.00	24,810,333.67
2,102.00	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,355,512.67	37,666,180.72
210,201.00	Тэтгэврийн даатгал	27,807,522.60	26,414,415.33
210,202.00	Тэтгэмжийн даатгал	-	2,858,251.62
210,203.00	ҮОМШӨ-ний даатгал	2,286,710.03	2,303,941.55
210,204.00	Ажилгүйдлийн даатгал	407,350.45	532,624.01
210,205.00	Эрүүл мэндийн даатгал	5,853,929.59	5,556,948.21
2,103.00	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,923,581.00	53,027,506.96
210,301.00	Гэрэл, цахилгаан	2,501,099.00	2,428,217.88
210,302.00	Түлш, халаалт	43,973,906.00	46,628,061.10
210,303.00	Цэвэр, бохир ус	4,448,576.00	3,971,228.00
2,104.00	Хангамж, бараа материалын зардал	6,441,450.00	7,059,050.50
210,401.00	Бичиг хэрэг	600,400.00	1,108,300.00
210,402.00	Тээвэр, шатахуун	238,900.00	240,000.00
210,403.00	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	845,460.00	913,230.50
210,404.00	Ном, хэвлэл	135,000.00	50,000.00
210,405.00	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	236,000.00	96,000.00
210,406.00	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,385,690.00	5,251,500.00
2,105.00	Нормативт зардал	29,488,280.00	16,542,200.00
210,501.00	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	345,000.00	550,000.00
210,502.00	Хоол, хүнс	21,643,280.00	15,992,200.00
2,106.00	Эд хогшил, урсгал засварын зардал	5,200,000.00	2,800,000.00
210,603.00	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,200,000.00	800,000.00
210,604.00	Урсгал засвар	4,000,000.00	2,000,000.00
2,108.00	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	544,000.00	1,266,000.00
210,801.00	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	-	618,000.00
210,802.00	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
210,806.00	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	
2,109.00	Бараа үйлчилгээний бусад зардал	436,500.00	9,114,500.00
210,902.00	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	436,500.00	9,114,500.00
213.00	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,942,525.33	5,580,795.46
2,132.00	Бусад урсгал шилжүүлэг	10,090,374.00	1,920,000.00
213,208.00	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан алоан хаагчдал төрөөс үзүүлэх дэмжлэг	8,187,036.00	
213,209.00	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,903,338.00	1,920,000.00
2,134.00	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,930,219.00	96,193.02
213,403.00	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,930,219.00	96,193.02
2,135.00	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,921,932.33	3,564,602.44
213,503.00	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,921,932.33	3,564,602.44
3.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	20,497,000.00	24,993,650.00
5.00	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	20,497,000.00	24,993,650.00
22.00	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,497,000.00	24,993,650.00
2,200.00	Дотоод эх үүсвэрээр	20,497,000.00	24,993,650.00
225,106.00	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	20,497,000.00	24,993,650.00
6.00	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН	(20,497,000.00)	(24,993,650.00)

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2.00</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	446,568,400.00	442,907,604.54
<b>21.00</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	446,568,400.00	442,907,604.54
<b>210.00</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	444,648,400.00	440,987,604.54
<b>2,101.00</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	290,583,000.00	287,918,536.34
210,101.00	Үндсэн цалин	265,500,000.00	263,108,202.67
210,104.00	Урамшуулал	25,083,000.00	24,810,333.67
<b>2,102.00</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	38,552,800.00	37,666,180.72
210,201.00	Тэтгэврийн даатгал	26,737,400.00	26,414,415.33
210,202.00	Тэтгэмжийн даатгал	2,953,800.00	2,858,251.62
210,203.00	ҮОМШӨ-ний даатгал	2,363,100.00	2,303,941.55
210,204.00	Ажилгүйдлийн даатгал	590,800.00	532,624.01
210,205.00	Эрүүл мэндийн даатгал	5,907,700.00	5,556,948.21
<b>2,103.00</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	53,123,700.00	53,027,506.98
210,301.00	Гэрэл, цахилгаан	2,370,000.00	2,428,217.88
210,302.00	Түлш, халаалт	46,553,700.00	46,628,061.10
210,303.00	Цэвэр, бохир ус	4,200,000.00	3,971,228.00
<b>2,104.00</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,663,500.00	7,659,030.50
210,401.00	Бичиг хэрэг	1,110,000.00	1,108,300.00
210,402.00	Тээвэр, шатахуун	240,000.00	240,000.00
210,403.00	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	916,000.00	913,230.50
210,404.00	Ном, хэвлэл	50,000.00	50,000.00
210,405.00	Хөг хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	96,000.00	96,000.00
210,406.00	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,251,500.00	5,251,500.00
<b>2,105.00</b>	<b>Нормативт зардал</b>	16,542,400.00	16,542,200.00
210,501.00	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	550,000.00	550,000.00
210,502.00	Хоол, хүнс	15,992,400.00	15,992,200.00
<b>2,106.00</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	27,800,000.00	27,793,650.00
210,601.00	Багаж, техник, хэрэгсэл	6,000,000.00	6,000,000.00
210,602.00	Тавилга	19,000,000.00	18,993,650.00
210,603.00	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	800,000.00	800,000.00
210,604.00	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00
<b>2,108.00</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,268,000.00	1,266,000.00
210,801.00	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	620,000.00	618,000.00
210,802.00	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	648,000.00
<b>2,109.00</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	9,115,000.00	9,114,500.00
210,902.00	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,115,000.00	9,114,500.00
<b>213.00</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,920,000.00	1,920,000.00
<b>2,132.00</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,920,000.00	1,920,000.00
213,209.00	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,920,000.00	1,920,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	446,568,400.00	442,907,604.54
<b>1,310.00</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	391,444,700.00	387,880,097.56
131,007.00	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	391,444,700.00	387,880,097.56
<b>1,320.00</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	55,123,700.00	55,027,506.98
132,001.00	Орон нутгийн төсвөөс	55,123,700.00	55,027,506.98

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Есөнбулаг сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Монголиан бизнес рейтинг аудит” ХХК-ний Говь-Алтай салбарын захирал, аудитор Р.Цанжидмаа гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Есөнбулаг сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 04 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх, хүүхдийг бие бялдарын хувьд эрүүл чийрэг өсгөж хөгжүүлэх ариун цэвэр эрүүл ахуйн зөв дадал хэвшилтэй болгох, хэл яриа сэтгэхүйн чадвар эзэмшүүлэх хүрээлэн байгаа орчин юмс үзэгдлийн талаар анхны мэдэгдэхүүнтэй болгох.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Есөнбулаг сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт орлого 490.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 9.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 7.8 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Есөнбулаг сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 60.5 хувиар буюу 260.7 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 75.0 сая төгрөг болж 14.2 сая төгрөгөөр өссөн нь хангамжийн материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 34.8 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 1.5 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 21.6 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 75.0 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 707.7 сая төгрөг болж 249.6 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 24.9 сая төгрөг, хандив тусламжийн хөрөнгөөр 271.1 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй орлого авсан.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 691.5 сая төгрөг болж 260.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 45.9 хувиар буюу 238.1 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 122.9 сая төгрөгийн алдагдалтай болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,063.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 616.8 сая төгрөгөөр бууруулж, 446.6 сая төгрөгөөр баталжээ.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 446.6 сая төгрөгийн төсөв баталснаас 391.4 сая төгрөгийг улсын төсвөөс 55.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 391.4 сая төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 55.1 сая төгрөгийн санхүүжилт авч нийт 446.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 422.9 сая төгрөгийг зарцуулж 3.6 сая төгрөгийг улсын төсөвт, 0.09 сая төгрөгийн орон нутгийн төсөвт тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 442.9 сая төгрөг буюу 99.2 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 2.7 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 0.9 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 0.09 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим системд 979.9 сая төгрөгийн 147 мэдээллийг ил тод байршуулахаас 979.9 сая төгрөгийн 147 мэдээллийг ил тод байршуулсан ба 2 мэдээллийг хугацаа хоцруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан

авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 8.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 02 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан үндсэн хөрөнгийн чанар, ашиглалтын байдал
- Нягтлан бодох бүртгэлийн дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийн шинж чанар, үнэнд дүн шинжилгээ хийх

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 10.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.2 сая төгрөгийн алдаа залруулж, 0.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 9.6 сая төгрөгийн зөрчил, батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад Дэлхийн зөн Монгол Олон Улсын байгууллагаас нийлүүлсэн хөрөнгийг орлого аваагүй 0.2 сая төгрөгийн алдааг залрууллаа.

### 4.2 Төлбөрийн акт

Улирлын үр дүнгийн урамшууллыг 0.2 сая төгрөг илүү олгосон нь ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.3-т "Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сургалтын байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргээ гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй багш, туслах багш, бусад албан хаагчид олгоно", 4.7-т "Энэ журмын 4.3-т заасан нөхцөлийг хангасан багш, албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг тухайн сургалтын байгууллагын эрхлэгч, захирал гаргана" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Хоолны зардлын норматив 0.7 сая төгрөгөөр хэтрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Засгийн газрын 2019 оны хоолны зардлын нормативд тогтоох 450 дугаар тогтоолын 1дүгээр заалт" Цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 2475 төгрөгөөр, 24 цагаар ажилладаг, сувиллын болон тусгай цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 3600 төгрөгөөр тогтоосугай" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт хүргүүллээ.

### 4.3 Албан шаардлага

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай"-ын 1.4-д заасан "Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад авто машин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт

хувцас, амралт, алжаал тайлан, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлаагүйгээр 9.6 сая төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын 1.4 дэх заалт" ТБОНӨХ-өөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад авто машин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ

#### 4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй

#### 1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Есөнбулаг сумын 3 дугаар цэцэрлэг	5	10.7	1	0.2	2	0.9	2	9.6		
	Дүн	5	10.7	1	0.2	2	0.9	2	9.6		